

**МОНГОЛЫН НОГООН НАМЫН ТЭРГҮҮЛЭГЧИД,
ИРГЭНИЙ ЗОРИГ НАМЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХАМТАРСАН ХУРЛААР САЙШААВ.**

2000.04.22.

УЛААНБААТАР

**“ИРГЭНИЙ ЗОРИГ-НОГООН НАМ” ЭВСЛИЙН
СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Монгол Улсын дэвшил, хөгжил, өөдрөг ирээдүйн төлөө амин хувийн эрх ашгаа огоорон иэгэн эгнээнд зориг шулуудан багтсан “Иргэний Зориг-Ногоон Нам” Эвсэл:

- Нийт үндэсний эрх ашгийг дээд шалгуур хэмээн үзэж, олны итгэл, эрх зүйн болон ёс суртахууны хатуу хариуцлагын зарчим,
 - Уламжлал, шинэчлэлийн харилцан шүтэлцээ, нандин барилдлага,
 - Нийгмийн нөхцөл байдлыг бодитой шинжлэн дүгнэж, хамгийн илүү үр өгөөжтэй, бүтээлч шийдлийг онож сонгох
- зарчмуудыг үйл ажиллагааныхаа чиг удирдамж болох ёстой хэмээн үзэж байна.

ХҮЧТЭЙ ШУДАРГА ТӨР, ЦЭГЦТЭЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨӨ

Монголчууд бид улс орон, нийгмийн хөгжлийн шинэ тогтолцоо, хэв загварыг эргэлт буцалтгүй сонгосноос хойш арван жил өнгөрч байна. Энэ хугацаанд ардчилсан нийгмийн үндэс суурь болох хүний сонголтын эрх чөлөө, хувийн өмчийг баталгаажуулах талаар багагүй ахиц амжилт олсон боловч эдийн засаг, нийгмийн сөрөг үр дагавар нэмэгдэж, төрийн бодлогын алдаа дутагдлын улмаас нийгмийн хөгжил урагшлахаасаа илүү ухарч саатах бодит аюул нүүрлэж байна. Улс орон, нийгэм, хувь хүний амьдралд хуулийг дээдлэн сахиж, шударга амьдрах нь хохиролтой, харин хууль зөрчих, завшин луйвардах нь ашигтай болох гаж дэг жаяг үйлчлэн, энэ нь төр засаг, иргэдийн өдөр тутмын амьдрал, үйл ажиллагаанд ноцтой мэдрэгдэх боллоо. Монголын нийгэм авлигад идэгдэж, зэрэмдэг ардчилал, арчаагүй дорой төрийн тогтолцоо бий болсон гэж бид дүгнэж байна.

Энэ байдлыг үндсээр нь халж өөрчлөхөд чухал шаардлагатай ардчилсан тогтолцооны хүрээнд үр өгөөжтэй ажиллах хүчтэй шударга төр, цэгцтэй, нийгэм-экологийн баримжаатай зах зээлийн эдийн засаг үгүйлэгдэж байна.

Ардчилсан тогтолцооны давуу талыг амьдралд бүрэн дүүрэн хэрэгжүүлэхийн тулд бид дараахь зорилго дэвшүүлж байна:

- Төр нь иргэнийнхээ эрхийг хамгаалж, хүчирхийлэл, гэмт хэргийг таслан зогсоох чадвартай, төрийн түшмэл, албан хаагчид нь хулгай хийх, худал ярих, гэмт хэргийн ертөнцтэй сүлбэлдэхийг цээрлэдэг төрийн зохион байгуулалт бий болгож хүчтэй шударга төрийг бэхжүүлэх,
- Цалин хөлс, ажлын байрыг нэмэгдүүлж, өрсөлдөх чадвар бүхий нийгэм, экологийн баримжаатай зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэх,

Бидний ойрын зорилт:

- Авлига хээл хахууль, төрийн өмчийг ашиглан цөлмөх үзэгдэлтэй тууштай тэмцэх,
- Төрийн засаглалын ардчилсан зарчмуудыг цэгцтэй хамгаалан, бэхжүүлэх,
- Эдийн засгийн ойрын болон хэтийн оновчтой бодлого боловсруулах,
- Иргэний нийгмийн байгууламжийг тууштай дэмжих,
- Ардчилсан нийгэмд иргэн бүр гагцхүү хуульд захирагдах зарчим хэрэгжүүлж, хуулийн ноёрхлыг жинхэнэ бодит байдалд тогтоох.

Чингэхийн тулд:

- 1) Хуулийн өмнө иргэн бүр адил тэгш бөгөөд удирдлагын аль ч түвшинд гэсэн хүн бүр хуулинд үг дуугүй захирагдах,
- 2) Мөнгө санхүү, улс төрийн нөлөөллөөс хараат бус, бие даасан, шударга, нийгмийн хүндэтгэл хүлээсэн шүүх засаглал бий болгох,
- 3) Хууль тогтоох үйл явц ил тод, олон нийтийг хамарсан, тэдний санал бодлыг тусгасан байх, хуулийг бодит амьдралд хэрэгжүүлэх санхүү эдийн засаг, боловсон хүчний үр ашигтай механизм бүрдүүлэх,
- 4) Ард түмнээс бүрэн эрх гардан авдаг төрийн түшээ нарын хариуцлагын механизмын чухал хөшүүрэг болгож, УИХ-ын халдашгүй дархан эрхийг хязгаарлан халж, тэднийг эгүүлэн татах эрх зүйн механизмыг сонгогчдын хувьд бүрдүүлэх,
- 5) "Иргэд хуулиар хориглоогүй бүхнийг хийж болно", харин "албан тушаалтан гагцхүү хуулиар зөвшөөрсөн зүйл хийх эрхтэй" гэдэг зарчим баримтлах,

8) Хувийн өмчийн эрх, дотоод, гадаадын хувь нийлүүлэгч, хөрөнгө оруулагчдын эрхийг хамгаалж, жижиг дунд үйлдвэрлэл, хувийн хөдөлмөрийг дэмжих,

9) Иргэдийн амьжиргааны гол эх үүсвэр болох цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжийн хэмжээг амьжиргааны өртөгтэй уялдуулан нэмэгдүүлж байх,

10) Бүх шатны сонгуулийн тогтолцооны үр нөлөөг дээшлүүлж, сонгуулийн хууль тогтоомжийг улс төрийн тоглоом, эрх мэдлээ хадгалах халхавч болгох аливаа оролдлогыг таслан зогсоох. Үүний тулд:

- Төрийн эрх барих дээд байгууллага УИХ-ын Сонгуулийн тухай хууль тогтоомжийн хэрэгжих хугацааг өөрчлөх асуудлыг тухайн УИХ-ын бүрэн эрхийн хугацаанд хэрэглэхгүй байх зарчим баримтлах,

- Бүх шатны сонгуулийн санхүүжилт ард түмэнд ил тод, нэн ялангуяа нэр дэвшигч, улс төрийн нам эвслийн санхүүжилтын асуудалд хатуу хяналт бий болгох тухай санал боловсруулж дэвшүүлэх,

- Орон нутгийн сонгуулийг УИХ-ын сонгуультай хамтатган явуулж, сум, ниймаг, Нийслэлийн засаг даргыг ард иргэд шууд сонгодог, сум, дүүргийн Засаг дарга нь баг, хорооны Засаг даргыг томилдог тогтолцоонд шилжүүлэх асуудлыг Үндсэн хуулинд өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэж, чингэснээр орон нутгийн засаглалд оршиж буй эрх мэдлийн хомсдолыг арилгах,

9) Төр засгийн байгууллагад ажиллагсдыг улс төрийн албан тушаалтны "баг" гэгчээр бүрдүүлж, үзэл бодол, намын харьяаллаар нь гадуурхах гажуудлыг арилгаж, төрийн ажлын мэдлэг, зүтгэл, ажиллах чадварыг гол шалгуур болгож, төрийн албыг төлөвшүүлэх,

10) Авлигын эсрэг тэмцэл үр дүнтэй байх гол нөхцөл нь улс төрийн удирдлагын хүсэл зориг болохоор төрийн захиргаа, удирдлагын түвшинд түгээмэл болсон авлигыг даван туулах зорилгоор:

- Төрийн албан тушаалтны төрийн албанд тогтвортой ажиллах сонирхол, хариуцлагыг дээшлүүлэх,

- Албан тушаалтны дангаар шийдвэрлэх асуудлын тоог боломжийн доод хэмжээнд хүргэж, хуулиар нарийн журамлан тогтоох,

- Албан тушаалтан аливаа шийдвэрийг олон санал өрсөлдүүлэх замаар гаргадаг байх (улсын захиалга, тендер гэх мэт),

- Албан тушаалтны үйл ажиллагааг нээлттэй, ил тод байлгах, тэдний үйл ажиллагаанд тавих нийгмийн хяналтыг сайжруулах,

- Албан тушаалтан, түүний дотор ялангуяа төрийн өндөр албан тушаалтан хээл хахууль авч, албан тушаалаа хувьдаа ашигласан асуудлыг тухай бүрд нь нягтлан шалгуулж, хууль болон ёс зүйн үнэн бодитой үнэлэлт өгч, нийтэд үнэн зөв мэдээлж, цаашид төрийг хээл хахуулиас хамгаалах найдвартай тогтолцоо бий болгох,

- Авлига, хээл хахуулийн үзэгдлийг үл тэвчих уур амьсгал, сэтгэлгээг төлөвшүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийг боловсронгуй болгох, авлигын эсрэг тэмцэх тусгай хөтөлбөр, хараат бус байгууллага бий болгох, энэ хараат бус агентлаг нь
 - Авлига хээл хахуулийн хор уршиг, түүнд үл автах асуудлаар сургаж боловсруулах, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулах,
 - Хүнд суртал, зөвшөөрлийн тогтолцоог халах зэргээр авлига хээл хахуулиас урьдчилан сэргийлэх,
 - Авлигын хэргийг мөрдөн шалгах, шүүхэд нэхэмжлэх эрхтэй үндэсний бодлого хэрэгжүүлэх байгууллага байх ёстой.

11) Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулах:

Чөлөөт хэвлэл мэдээлэл нь Монголын нийгэмд ардчиллыг бэхжүүлэхэд цаглашгүй их үүрэг гүйцэтгэж, үнэт хувь нэмрээ оруулсаны зэрэгцээ сүүлийн жилүүдэд хэвлэл мэдээллийн хэрэгсэл (нэн ялангуяа төрийн нөлөөллийн хүрээний) засгийн эрх баригчдын хатуу хяналтанд оршиж нэрвэгдэн, олон нийтийн мэдээллийн гэхээсээ илүү эрх баригчдын суртал ухуулгын хэрэгсэл болон хувирсаар байгаа харамсалтай үзэгдлийг даван туулах нь чухал байгааг цөхон тэмдэглэж байна.

Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн төр засаг, санхүү-бизнесийн бүлэглэлээс хараат бус байдлыг хууль тогтоомж болон улс төрийн нөхцлийг бүрдүүлэх замаар бодитойгоор бэхжүүлэх зорилтыг бид дэвшүүлэн тавьж байна.

- Төр засгийн байгууллагаас мэдээлэл олж авах боломжийг хялбаршуулж, улсын нууцад үл хамаарах аливаа мэдээллийг нээлттэй байлгах нөхцөл бүрдүүлэх,
- Эрэн сурвалжлах сэтгүүл зүйг жихэнэ утгаар хөгжүүлж, баримт сэлтэнд тулгуурласан нийтлэлийн бодлогыг төрөөс тууштай дэмжих,
- Хэвлэл мэдээллийн мэргэжлийн байгууллагаас сэтгүүлчдийн ёс зүй, Үйл ажиллагааны дүрмийг баталж гаргах, түүнчлэн сэтгүүлчдийн сургалтанд төсвийн хөрөнгөнөөс дэмжлэг туслалцаа үзүүлэх,
- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийгмийн сөрөг үзэгдэл, нэн ялангуяа авлига, хээл хахуулийн талаар мэдээлэх, нийтлэхийг дэмжиж, олон түмэнд үнэн зөв мэдээлэл түгээх,

Бидний дэвшүүлж буй нийгмийн зорилт:

Хүн амын орлогыг нэмэгдүүлэх болон нийгмийн хамгааллын тогтолцоог бэхжүүлэх

- Төсвөөс гаргаж буй цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж олгохсд гарч байгаа аливаа саатал доголдлыг арилгах, хөдөлмөрийн хөлсийг саатуулсан ажил

- Үнийн өсөлттэй уялдуулан хүн амын орлогын хэмжээг өсгөх, хүн амын амьжиргааны бодит түвшин эрс доройтох үзэгдэл гаргахгүй байх нөхцөл бүрдүүлэх,
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг бодитой тооцож, амьжиргааны баталгаажих доод түвшинд хүргэх,
- Төсвийн ажилчдын цалингийн дундаж хэмжээг албан ёсны эдийн засгийн хөдөлмөрийн хөлсний дундаж түвшинд хүргэх,
- Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг амьжиргааны баталгаажих доод түвшинд хүргэх,
- Нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг тууштай хэрэгжүүлэх,
- Нийгмийн халамжийн хүрээг илүү оновчтой тогтоож, үр дүнг нэмэгдүүлэх,
- Хөдөлмөрийн чадваргүй, ялангуяа тахир дутуу иргэд, хүүхэд багачуул, өрх толгойлсон олон хүүхэдтэй эмэгтэйчүүдийн нийгмийн баталгааны асуудлыг онцгойлон анхаарах,

Боловсрол

Иргэний Зориг Нам - Ногоон Нам Эвсэл нь нийгмийн хөгжлийн үндсийг боловсролын салбарын хөгжил дэвшилтэй шууд холбоотой гэж үзнэ.

- Суурь боловсролыг төрөөс онцгойлон дэмжих, багш бэлтгэх тогтолцоог дорвитой сайжруулж, багшийн нийгмийн нэр хүндийг дээшлүүлэх зэргээр боловсролын шинэтгэлийг тууштай үргэлжлүүлнэ.
- Иргэдийн нийтлэг, төлбөргүй боловсрол эзэмших эрхийг баталгаажуулж, боловсролыг тэргүүлэх чиглэл болгох зорилтыг тууштай баримтлах,
- Мэдлэг боловсролын чанар, үр дүн, бодит амьдралд хэрэглэхүйц практик чиглэлийг хангаж, улс орон, нийгэм, хувь хүний шаардлагад тулгуурласан сонгон суралцах боловсролыг дэмжих,
- Боловсролын салбар дахь авлигын эсрэг шийдвэртэй тэмцэл өрнүүлэх,
- Сургууль, боловсролын байгууллагын бие даасан хараат бус байдлыг төлөвшүүлэх, боловсролын салбарыг нийгэм-төрийн удирдлагаар хангах,
- Их, дээд сургуулийн сургалтын үр ашиг, чанарыг дээшлүүлэх зорилгоор хяналт үнэлгээний тогтолцоог чангатгаж, сайжруулна.
- Боловсролын салбарт оруулж буй хөрөнгө оруулалтын чиглэлийг оновчтой болгох,
- Сурган хүмүүжүүлэх байгууллагад тавих шаардлагыг нээлттэй болгох, ялангуяа уралдаант шалгалт олон нийтэд нээлттэй байх, боловсролын салбарт шийдвэр биелүүлэх үйл явцад хатуу хяналт тавьж хариуцлага тооцож байх,
- Нэг загварын багш төвтэй сургалтаас татгалзаж, ерөнхий боловсролын болон мэргэжлийн сургуулийг олон хэвшлийн шавь төвтэй сургалтанд хандуулан, суралцагчдын чөлөөт сонголт хийх эрх зүйн орчин бүрдүүлэх талаар санаачилга гаргаж ажиллах,

- Хөдөө орон нутагт бага ангийн сурагчдын алсын зайн сургалтыг уламжлалт болон шавь сургалттай хослуулах тогтолцоо бий болгох,
- Сурах хүсэл сонирхолтой, авьяаслаг хүүхэд залуучуудыг гадаад, дотоодын мэргэжлийн сургуульд төрийн зардлаар суралцуулах бодлогыг тууштай баримтлах,
- Нийгмийн сэтгэл зүйг оновчтой зөв төлөвшүүлэхэд чиглэсэн соёл, урлагийн хүмүүнлэг бизнесийг дэмжих,

Шинжлэх ухаан

- Нэгэнт бүрэлдэн тогтсон шинжлэх ухааны салбарыг улам эрчимтэй хөгжүүлэхийн хамт шинэ технологи боловсруулах, эзэмших, ялангуяа эх орны үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэхэд түлхэц өгөх технологи боолвсруулан хэрэгжүүлэх судалгаанд түлхүү анхаарна. Үндэсний эрдэмтэн, инженер-техникийн ажилтны эх орны үйлдвэрлэл, түүхий эдийн боломж, нөөцөд зохицуулан боловсруулсан технологийг амьдралд хэрэгжүүлэх ажлыг тэргүүн зэрэгт тавихын зэрэгцээ гадаадын шалгарсан дэвшилтэт технологийг эх орны үйлдвэрлэлд тохируулан эзэмших асуудлыг хөхиүлэн дэмжинэ.
- Шинжлэх ухаан, боловсролын тасралтгүй холбооны зохистой агуулга, хэлбэрийг үндэсний өвөрмөц нөхцөлд тохируулан хөгжүүлнэ.
- Эх орны шинжлэх ухаан, технологийн судалгаанд зарцуулах хөрөнгийг улсын төсвийн 2 хувь хүртэлх хэмжээнд хүргэн нэмэгдүүлж, судалгааны ажлын материаллаг баазыг сайжруулахад зориулан хөрөнгө оруулалт хийнэ.
- Оюуны хөдөлмөрийн үнэлэмжийг дэлхийн төвшинд ойртуулж эрдэмтэд, шинжлэх ухаан, технологийн боловсон хүчний хөдөлмөрлөх нөхцөл, амьжиргааны баталгааг сайжруулна.
- Шинжлэх ухаан, технологийн судалгаанд хөрөнгө оруулалт хийсэн дотоод, гадаадын байгууллага, компани, иргэдийг татвараас тодорхой хувиар ба бүрэн чөлөөлөх эрх зүйн үндсийг бий болгоно.

Эрүүл мэнд

Хуучин нийгмийн сэтгэлгээнээс улбаатай өвчин эмгэгийг эмчлэхийг голчилдог тогтолцоог өөрчилж, өвчлөхөөс урьдчилан сэргийлэх аргыг урьдал болгосон тогтолцоонд үе шаттайгаар шилжих нь эрүүл мэндийн салбарын шинэтгэлийн гол агуулга болно. Шинэтгэлийг бодит амьдралд хэрэгжүүлэх санхүүгийн хөшүүрэг, бусад механизмыг бүрдүүлэх нь нэн чухал гэж үзнэ.

Эдийн засгийн зорилтууд

Төсвийн орлого нэмэгдүүлэх чадвар бүхий албан ёсны эдийн засгийг урамшуулан дэмжиж, албан бус, сүүдрийн эдийн засгийг хамруулах замаар ажилгүйдлийг бууруулж, ядуурлын өсөлтийг зогсоох чадвартай эдийн засгийн өсөлтөнд шилжих нь эдийн засгийн хөгжлийн гол зорилт юм.

Үүний тулд:

Төр засагт итгэх итгэлийг сэргээх

Төр засагт хандах хүн ард, бизнесийнхний итгэл бол аливаа эдийн засгийн тогтолбөрийг хэрэгжүүлэх урьдчилсан нөхцөл гэж үзнэ. Төр засагт итгэх итгэлийг сэргээхийн ач холбогдлыг дараахь зүйлтэй холбож байна. Үүнд:

- Энэ нь орлого, мөнгөний эх үүсвэр болно;
- Иргэдийн хадгаламжийг баталгаажуулж, улмаар хөрөнгө оруулалт болгон, хууль ёсны эргэлтэнд оруулна.
- Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татна.
- Үндэсний мөнгөн тэмдэгтийг бэхжүүлнэ.
- Бодит ашиг бүхий салбарт банкууд зээл олгоно.

Төр засагт итгэх итгэлийг хэрхэн баталгаажуулах вэ.

- Засгийн газрын үйл ажиллагаа нээлттэй, урьдчилан тооцох бололцоотой байх,
- Хичнээн хүнд хэцүү байлаа ч гэсэн бодит байдлыг үнэн зөв мэдээлж байх,
- Төсөв бодитой байх,
- Төрийн мэдлийн нөөц баялгийн (төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, гэх мэт) ашиглалт ил тод, хяналттай байх,
- Хөрөнгө оруулагчидтай тогтвортой, шударга харилцах

Банк, мөнгөний тогтолцоог эрүүлжүүлэх явдлыг тэргүүн зэргийн ач холбогдолтой гэж үзнэ. Хөрөнгө оруулалтын банк байгуулж, хадгаламж, тээлийн даатгалын сан байгуулж хөгжүүлэх явдлыг хөхиүлэн дэмжих бодлого хэрэгжүүлнэ. Энэ зорилгоор банкны бус санхүүгийн компани, даатгалын болон үнэт цаасны хувийн компани, жижиг зээлийн байгууллагыг дэмжсэн бодлого баримтална.

- Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлого тууштай хэрэгжүүлнэ.
- Эрүүл мэнд, эрүүл ахуйн шаардлагын үүднээс хүн амын хэрэглээний гол бараанд мэргэжлийн нарийн хяналт тавих журам тогтоож, аливаа хорт үйлээс сэргийлэх чанд бодлого явуулна. Хүнсний ногоо, өндөг, төрөл бүрийн мах, сүүг зах дээр худалдах эрхийг зөвхөн үйлдвэрлэл эрхлэх эрхийн баталгаа бүхий хүмүүст олгож, эмнэлэг-ариун цэврийн хяналтыг хүчтэй болгоно.
- Хот хөдөөгийн хүн амьд ойр, хүртээмжтэй, чанартай, үнэ төлбөргүй эрүүл мэндийн тусламж үзүүлэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр салбар хоорондын дэд бүтцийн сүлжээг бий болгоно.
- Өндөр настан, ахмад үеийнхэнд үзүүлэх эрүүл мэндийн тусламжийн чанарыг сайжруулахад онцгой анхаарна.
- Сайн дурын даатгалын сан бий болгох замаар орчин үеийн тоног төхөөрөмж бүхий дээд зэрэглэлийн эмнэлэгийн үйлчилгээг хөгжүүлэхийн төлөө байна.
- Хүн амын өвчлөлийн байдал, эрүүл мэндийн хэрэгцээг судалсны үндсэн дээр зардал ихтэй, олон ортой том эмнэлэгүүдийг задалж, овор багатай цөөхөн ортой эмнэлэгээс гадна өдрийн сувилал, асрамж халамжийн газар, уламжлалт эмнэлэг, оношлогооны болон эмийн бус эмчилгээний төв зэрэг янз бүрийн хэлбэртэй эрүүл мэндийн олон хэвшлийн байгууллагыг бий болгож, тэдгээрийг өрсөлдүүлэх замаар эмч ажилчдын цалинг нэмэгдүүлэх бодлого явуулна.
- Эрүүл мэндийн олон хэвшлийн байгууллага бий болж байгаа нөхцөлд үйлчилгээний чанар, стандарт, технологийг мэргэжлийн өндөр түвшинд хянах механизмыг төгөлдөржүүлж, анагаах ухааны боловсрол олгодог сургуулиудын оюутны сургалтыг эрүүл мэндийн практик үйл ажиллагаатай нягт уялдуулах чиглэл баримтлана.
- Хувийн эмнэлгээр эмчлүүлэгчдийг даатгалын тогтолцоонд бүрэн хамруулна.
- Монгол Улсын хэмжээнд нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүйгээр эмчлэх, эмчлүүлэх зарчим баримтлана.

Гэр бүл, эмэгтэйчүүд

- Залуучууд гэр бүл болж, бие даасан амьдралын гараагаа эхлэх, орон сууц барих, худалдаж авах, бизнес эрхлэх, сурч боловсроход нь төрөөс удаан хугацааны хөнгөлөлтэй зээл олгох тогтолцоог бий болгох бодлого хэрэгжүүлнэ.
- Эмэгтэйчүүдийн үнэлгээгүй хөдөлмөрийн асуудлыг шийдвэрлэх хуулийн төсөл боловсруулна.
- Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг явуулж байгаа бүхий л үйл ажиллагааг дэмжинэ.

Татварын бодлого

Эдийн засгийн өсөлтийг урамшуулахын тулд татварын ачааллыг цаашид эрс бууруулж, далд эдийн засгийг албан ёсны харилцаанд оруулах цогцолбор арга хэмжээ зайлшгүй чухал юм. Ийм арга хэмжээ авахгүй бол буурсаар байгаа төсвийн орлого бүр ч хүнд хэцүү байдалд орно. Татварын дарамтыг бууруулснаар татвар төлөх тогтолцоог энгийн хүртээмжтэй болгож, татвар төлөлтийн хяналтанд эерэг нөлөөлнө. Шууд бус татварт голлон тулгуурлаж, шууд татвар болон эргэлтийн хөрөнгийн татварын түвшинг бууруулах, татварын бүсчилсэн ялгаа буй болгох, иргэдийн орлогын болон бусад татварын тоог цөөрүүлэх, хялбаршуулах бодлого баримтална.

Татварын тогтолцооны шинэтгэлийн зорилго нь далд эдийн засгийг үе шагтайгаар албан ёсны эдийн засгийн хүрээнд оруулах явдал юм. Татварын шинэчлэлийн дараагийн алхам нь төсвийн орлого өсөх хэмжээгээр шууд бус татварын түвшинг багасгах явдал юм. Үйлдвэр аж ахуйн газар, иргэдийн далд орлогыг албан ёсны эргэлтэд оруулснаар төсвийн орлого нэмэгдэх болно. Гэхдээ татварын шинэчлэлтийг хэрэгжүүлж эхэлснээр төсвийн орлого хэдэн сарын турш ямар нэг байдлаар буурч болох юм. Гэвч энэ нь эдийн засгийн бодлогын цаашдын арга хэмжээний үр дүнд нөхөгдөнө.

Төсвийн бодлого

- Төсвийн сахилгыг бэхжүүлэх. Энэ нь төсвийн бүхий л орлого зарлагын тооцоо, санхүүгийн чанд нарийн хяналт шалгалтаар хэрэгжинэ. Улсын захиалга болон бараа бүтээгдэхүүн худалдан авахад үйлдвэр, аж ахуйн нэгжүүд өрсөлдөөний журмаар оролцдог байх, төсвийн болон төсвийн гадуурх санд хяналт шалгалтын горим тогтоох зэрэг болно.
- Жам ёсны монополь болон татвар төлөгч томоохон аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн болон татвартай холбоотой үйл ажиллагааг цэгцтэй болгоно.
- Төсвийн зарцуулалтад бүхэлд нь хяналт тавина. Орон нутгийн төсвийн зарцуулалтад тавих хяналтыг чангатгана.
- Төрийн мэдлийн өмч, хөрөнгө ашиглалтын орлогыг нэмэгдүүлнэ. Мөн улс орны байгалийн нөөц баялгийг ашигласны төлбөрийн хэмжээг ихэсгэнэ.
- Аж үйлдвэрийн бодлогыг төрийн албан тушаалтны мэдлээс чөлөөлж, энгийн хялбар болгоно. Үүний тулд улс даяар хөрөнгө оруулалт хийх 10-15 томоохон төсөл хэрэгжүүлнэ. Эдгээр төсөл нь зохих хөнгөлөлттэй байхын зэрэгцээ хуульчлагдсан байна. Мөн улс оронд тэргүүн зэргийн ач холбогдолтой хөтөлбөр, арга хэмжээнд татвар болон гаалийн хөнгөлөлт үзүүлэх нь зөв зүйтэй гэж үзнэ.
- Эдийн засгийн өсөлт нь хөрөнгө оруулалтгүйгээр явагдахгүй. Харин хөрөнгө оруулалт нь үйлдвэр аж ахуйн газрыг урт хугацаанд хөгжүүлэхийг сонирхож буй хувийн өмчтөнгүйгээр хийгдэх боломжгүй. Үүний тулд дараахь арга хэмжээ хэрэгжүүлнэ:

- Өмч эзэмших эрх, ялангуяа эдийн засгийн чухал ач холбогдолтой үл хөдлөх хөрөнгө эзэмших эрхийг найдвартай баталгаажуулсан хууль тогтоомж батлан гаргана.
 - Үл хөдлөх хөрөнгийн эргэлтийг сайжруулж, үйлдвэрлэл өөрийгөө санхүүжүүлэх боломжийг татварын бодлогоор дэмжин бий болгоно.
 - Жижиг дунд бизнесийн зохицуулалтыг шинэчилж, аж ахуйн нэгжийг бүртгэх, бүртгэлээс хасах механизмыг хөнгөвчлөнө.
 - Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хуулиар баталгаажуулна. Менежерийн үйл ажиллагаа болон хөрөнгийн зах зээл дэх хувьцаа эзэмшигчдийн хяналтыг сайжруулна.
- Өмч хувьчлалаас төр орлого олох ёстой гэсэн байр суурийг өөрчилж, өмч хувьчлал нь ажлын байр нэмэгдүүлэх, үр ашигтай удирдлага, хөрөнгө оруулалтыг татах нөхцөл бий болгох ёстой гэж үзнэ.
 - Хөрөнгө оруулах болон хувьцаа эзэмших өрсөлдөөнд төрийн зүгээс дүн шинжилгээ хийж, хөрөнгө оруулагч гэрээгээр хүлээсэн үүргээ эс биелүүлбэл шүүхийн дагуу шийдвэрлэж байна.
 - Үйлдвэрийн газрын дампуурлыг зохицуулах болон удирдлага зохион байгуулалтыг үр ашигтай болгох механизм бий болгож, бүрдүүлэхийг дэмжинэ.
 - Үндэсний менежер, мэргэжилтнийг хилийн чанадад сургах хөтөлбөр хэрэгжүүлнэ.

Олон улсын хамтын ажиллагаа, гадаад харилцааг Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хүрээнд идэвхжүүлэн хөгжүүлж, Монгол улсын байр суурийг олон улсын тавцанд бататган бэхжүүлж, хөрш улсуудтай бие биеэ харилцан хүндэтгэх, эрх тэгш хамтран ажиллах бодлого хэрэгжүүлнэ.

Гадаадын зээл тусламжийн ашиглалтын үр ашгийг дээшлүүлэх, ажил эрхлэлт, үндэсний үйлдвэрлэлийн тэргүүлэх салбарын хөгжилд үзүүлэх бодитой үр нөлөөг онцгойлон анхаарсан бодлогыг дэмжинэ. Гадаад өрийн эдийн засагт учруулах дарамтыг тооцох, олон нийтэд мэдээлэх ажлыг чухалчилж үзнэ.

Олон улсын аялал жуулчлал хөгжүүлэх цогцолбор төсөл боловсруулан хэрэгжүүлж эхлэнэ.

Хөдөөгийн хөгжил, хүрээлэн буй байгал орчны бодлого

Хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуйг татан буулгаж, мал, үндсэн хөрөнгийг нь хувьчилж, үнэ чөлөөлсөн төдийгөөр хөдөө аж ахуй зах зээлд шилжсэн мэт ойлгож байгаа өнөөгийн төрийн бодлогыг эрс шүүмжилж,

хөдөө аж ахуйг тогтвортой хөгжлийн замд оруулж, хөдөөгийн хөгжлийн бодлогыг иж бүрнээр нь шийдвэрлэхийн төлөө байна. Үүний тулд:

- Өвс тэжээл бэлтгэх, худаг ус гаргах, мал эмнэлэг, ариун цэвэр, малын үүлдэр угсаа сайжруулах, бүтээгдэхүүнээ борлуулахад хүчин мөхөсдөж байгаа өнөөгийн өрхийн жижиг аж ахуйнуудад байгалын, үйлдвэрлэлийн болон маркетингийн эрсдлээс хамгаалах чадвартай болход нь туслах үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ,
- Төрийн үйлчилгээг малчид, хөдөөгийн иргэдэд шуурхай, чанартай хүргэх, хөдөлгөөнт холбоо, цахилгааны эх үүсвэрээр хангах асуудлыг өйрын хугацаанд шийдвэрлэнэ.
- Мал аж ахуйн орлогын албан татварыг малчдад ойлгомжтой хэлбэрээр бүс нутгийн онцлогт тохируулан тогтооно.
- Мал аж ахуйн тогтвортой хөгжлийн үндэс болсон бэлчээр талхлагдах аюулаас хамгаалах, алсын бэлчээр эзэмших, усжуулах ажлыг төрийн дэмжлэгтэй хэрэгжүүлнэ.
- Газар тариалан, нэн ялангуяа үр тарианы үйлдвэрлэлийг зээл, хөрөнгө оруулалт, татвар, гаалийн бодлогоор дэмжих хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- Тариалангийн газрыг тариаланчдад удаан хугацааны хөнгөлөлттэй түрээсээр эзэмшүүлэх замаар газрын үржил шимийг сайжруулах, хөрөнгө оруулалт хийх сонирхлыг нэмэгдүүлнэ.
- Мал аж ахуй, газар тариалан эрхлэгчдийг бүтээгдхүүнээ хадгалах, боловсруулах зориулалтын бага оврын тоног төхөөрөмжөөр хангах, энэ чиглэлийн жижиг дунд үйлдвэрлэлийг хөдөөд байршуулах замаар хөдөөгийнхний орлогыг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлнэ.
- Эдийн засаг, нийгэм, байгал орчин, хүний хөгжлийн хүрээнд бий болсон бэрхшээл болон нэмэгдэж буй нутаг дэвсгэрийн ялгаварыг багасгаж, хөдөөд хүний ая тухтай амьдрах нөхцөл бүрдүүлэхэд чиглэсэн бүсчилсэн хөгжлийн бодлого боловсруулж, хэрэгжүүлнэ.
- Гадаадын зээл, тусламжийг хөгжилд зориулах бодлого баримталж, өндөр үр ашигтай үйлдвэр байгуулах, бүх салбарт технологийн шинэчлэлт хийх, дэд бүтцийг хөгжүүлэхэд ашиглана. Гадаадаас авсан зээл тусламжийн зориулалт, ашиглалтыг нэгдмэл удирдлагаар хангаж, түүнийг олон түмэнд ил тод, бүрэн мэдээлдэг болгоно.
- Монгол улсын ХАА-д учирсан хохирлыг арилгах зорилгоор Байгалийн гамшигтай тэмцэх сан байгуулж, малжуулах хөтөлбөрийг олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.
- ХАА-н даатгалын үр ашигтай тогтолцоог хөгжүүлэх замаар тус салбарт эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг дэмжинэ.
- Байгалын гамшигтай тэмцэх шуурхай арга хэмжээг хэрэгжүүлэхийн зэрэгцээ байгалын гамшигаас учирсан хохирлыг арилгах эрх зүйн үндсийг бүрдүүлнэ. Мал эмнэлгийн үйлчилгээ, үржил селекцийн ажлыг төрийн ивээл хяналтанд байлгахын сацуу өмчийн бусад хэлбэрт түшиглэсэн мал эмнэлэг, үржлийн албыг дэмжинэ.

- Бэлчээрийн даацыг нэмэгдүүлэх зорилгоор үлийн цагаан оготнотой хийх тэмцлийг төрөөс зохион байгуулж, улмаар усны нөөцийг нэмэгдүүлэх, уст цэгийг сэргээн засварлаж шинээр байгуулахад дэмжлэг үзүүлнэ.
- Нар, салхины эрчим хүчийг ашиглан багийн төв, малчин өрхийг цахилгааны эх үүсвэртэй болгож, малчид радио сонсох, телевиз үзэх, холбооны хэрэгсэл ашиглах, хөдөлмөрөө хөнгөвчлөх нөхцөл бүрдүүлнэ.

Газрын шинэтгэл

- Газрыг төрийн хяналт, бүртгэл, хамгаалалтанд байлгаж, Монгол улсын иргэд газар нутгаа чөлөөтэй, баталгаатай эзэмшиж, ашиглах замаар газартай зөв харьцаж, амьдрал ахуйгаа дээшлүүлэх, улс орны эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн төрийн бодлогыг тууштай хэрэгжүүлнэ.
- Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших, ашиглах эрхийг өргөтгөн, хэрэгжих нөхцлийг нь баталгаажуулснаар газар, бусад үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулах сонирхлыг нэмэгдүүлнэ.
- Газрын эрх зүйн хувьд хоорондоо зөрчилтэй болон иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын газар эзэмших, ашиглах эрхийг хязгаарласан хууль тогтоомжийг өөрчилнө.
- Амьдралд нэгэнт бий болоод байгаа газрыг тодорхой зориулалтаар ашиглах эрхээ арилжих, барьцаалах үйл ажиллагааг хуулиар зохицуулж, энэ талын газрын харилцааг зах зээлийн жишигт нийцүүлнэ.

Хөдөө орон нутгийнхан эрсдэл нэн багатай, нийгэм эдийн засгийн өргөн ач холбогдолтой хоршоонд хамрагдахад нь дэмжлэг үзүүлэх тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ. Үүнд:

- Малчид тариаланчдын тогтвортой хөгжлийн өөдрөг ирээдүйн үндэс нь тэдний хоршсон үйл ажиллагаа хэмээн үзэж, хууль эрх зүйн таатай нөхцөл бий болгоно.
- Хөдөө орон нутгийн хоршоог эхний гурван жил аж ахуйн нэгжийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө.
- Байгуулагдсан хоршоо, нэн ялангуяа мал аж ахуйн гаралтай түүхий эдийн анхан шатны боловсруулалтын хоршоонд төрөөс хөрөнгө оруулалтын бодитой дэмжлэг үзүүлнэ.
- Хоршооны үйл ажиллагааг дэмжих замаар Монгол улсад бөөний худалдааны зах зээл хөгжүүлэх худалдаа үйлдвэрлэлийн өрсөлдөөнтэй, соёлтой харилцааг төлөвшүүлэх болно.
- Орон нутгийн банк санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх зорилгоор иргэдийн хадгаламж зээлийн хоршсон үйл ажиллагааг идэвхтэй дэмжихээс гадна орон нутгийн арилжааны банк байгуулах эрх зүйн үндэс болон орон нутгийн банкны дүрмийн сангийн хэмжээг бодитойгоор уян хатан зохицуулсан бодлого явуулна. Төрийн албан хаагчид хадгаламж зээлийн хоршоонд хамрагдах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

Орон нутгийн өөрөө удирдах ёс

- Орон нутгийн өөрөө удирдах ёс нь үр ашигтай эдийн засаг, нийгмийн нөөц олох иргэдийн өөрсдийн зохион байгуулалтыг ашиглах чадвар бүхий иргэний нийгмийн үндсэн бүрдэл юм. Бид нутгийн өөрөө удирдах ёсыг орон нутгийн дарга, албан тушаалтны дур зоргоор авирлах үзэгдлээс тууштай хамгаалах болно.
- Бид орон нутгийн өөрийн удирдлагын хариуцлагын тогтолцоог бэхжүүлж, иргэдэд улам нээлттэй ил тод, хяналтын тогтолцоо бий болгоно. Эрх мэдэл хувь хүн, явцуу бүлгийн эрх ашигт үйлчлэх, хүн амын эрх ашгийг үл тоомсорлох, иргэдийн шаардсан мэдээллийг өгөхөөс татгалзах, санхүүгийн үйл ажиллагааны хаалттай байдал зэрэг сөрөг үзэгдлийг таслан зогсооно.

Гэмт хэрэгтэй эрчимтэй тэмцэнэ

Гэмт хэрэг өсөж буйн гол шалтгаан нь ёс суртахуун болон үзэл бодлын чиг баримжаа алдагдсан байдал, хүн амын амьжиргааны нөхцөл эрс доройтсон, бодит амьдралд нийцэхгүй хууль тогтоомж олширсон, хууль сахиулах байгууллагын зохион байгуулалт илт суларсан зэрэгт оршиж байна. Гэмт хэрэг аль ч нийгмийн өвчин эмгэг. Ядуурал, ажилгүйдэлтэй тэмцэж, гэр бүлийг бэхжүүлэн, боловсролын тогтолцоог төгөлдөржүүлж, соёл боловсролд хөрөнгө оруулалт хийх нь чухал. Гэхдээ гэмт хэрэгтэй тэмцэхэд хамгийн гол нь улс төрийн удирдлагын зүгээс зориг шийдэмгий байх нь зүй. Эс тэгвэл хууль сахиулах байгууллагын хүчин чармайлт ямар ч үр дүнгүй болох юм.

- Иргэний, Эрүүгийн, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиудыг иж бүрэн цогцолбороор нь шинэчлэнэ.
- Улс төрийн зүтгэлтэн Санжаасүрэнгийн Зоригийн амь насыг хэрцгийгээр бүрэлгэсэн гэмт үйлдлийг илрүүлэхийн төлөө тууштай тэмцэнэ.
- Гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судлан нийгэмд учруулж буй хор аюул бүхий гэмт халдлагаас хүний амь бие, эрүүл мэнд, өмч хөрөнгийг тууштай хамгаалхад мэргэжлийн байгууллагын үүрэг хариуцлагыг өндөржүүлнэ.
- Шүүх, цагдаа болон мөрдөн байцаах байгууллагын материал, техник хэрэгслийн хангамжийг өнөөгийн шаардлагад нийцүүлэн холбоо мэдээллийн нэгдсэн сүлжээнд хамруулна.

Төрийн албаны өндөр туршлагатай боловсон хүчний нөөц манай намд бий. Бид нэгэн үзэл бодолтой бөгөөд харилцан ойлголцох, хамтран ажиллах чадвартай. Чухам үүнийг нэгэн зорилго, зориг эрмэлзэлтэй баг гэнэ.

Бид олон түмэнд хэзээ ч худал амлаж, хоёр нүүр гаргахгүй.

Бид олон түмний итгэлийг эрхэмлэн дээдлэнэ.

Иргэний Зориг нь хий хоосон шүүмжлэл биш, ажил хэрэг.